

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

№ 18/1

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж, хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав. Хурлаар бодлогын хүү, заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээ болон макро зохистой бодлогын стратегийн талаар хэлэлцлээ.

МБЗ-ийн хурлаар эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, эдийн засгийн өсөлт, эдийн засгийн гадаад орчин, хөдөлмөрийн зах, хөрөнгө санхүүгийн зах зээл, эдгээрт гарч буй өөрчлөлтийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Инфляци 2017 оны туршид эрчимжсэн ч мөнгөний бодлогын үндсэн зорилттой нийцтэй байсан ба цаашид зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байгааг МБГ-аас онцлов. Эдийн засгийн идэвхжил, зарим татварын өөрчлөлт, ХҮИ-ийн сагс, жин болон аргачлалын өөрчлөлт, цаг агаарын нөхцөл байдалтай холбоотой ургац алдалт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр жилийн инфляци нэмэгдсэн. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэж байгаа хэдий ч нэг удаагийн шинжтэй болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляци 2018 онд буурахаар хүлээгдэж байна.

Уул уурхайгаас хамаарал өндөртэй салбарууд¹ын идэвхжил эдийн засгийн өсөлтийг тодорхойлж байгааг онцоллоо. Эрэлт талаас 2017 оны эдийн засгийн өсөлтийг экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ өссөн, уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотойгоор хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа, эдийн засагт итгэх итгэл сайжирч бусад хөрөнгө оруулалтууд нэмэгдэж байгаа, өрхийн хэрэглээ өсч байгаа зэрэг нь голлон тайлбарлаж байна. Харин үйлдвэрлэл талаас ДНБ-ийн өсөлтөд нүүрсний экспорт, уул уурхайн салбарт хийгдэж буй бүтээн байгуулалттай холбоотойгоор худалдаа, боловсруулах болон тээвэр, агуулахын салбарын өсөлт хамгийн өндөр хувь нэмрийг оруулжээ.

Хөдөлмөрийн захын төлөв үргэлжлэн сайжирч байгаа бөгөөд эдийн засгийн бүх салбарт ажил эрхлэлт нэмэгдэж, ажилгүй иргэдийн тоо буурсан байна. Тодруулбал, ажиллах хүчний оролцооны түвшин тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 2 нэгж хувиар өссөн бол ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурсан дүнтэй гарсан.

Өмнөх бодлогын саналыг хэлэлцсэнээс хойш гадаад эрэлтийн төлөв сайжирсан болохыг танилцуулав. Үүнд Хятадын улсын эдийн засгийн өсөлт 2017 онд 4 дүгээр улиралд хүлээлтээс өндөр буюу 6.8 хувьд хүрсэн нь голчлон нөлөөлжээ. Түүнчлэн Хятадын эдийн засаг сүүлийн 3 улирлын турш шинжээчдийн хүлээлтээс давж өссөн нь цаашид эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл боллоо. Мөн 2017 оны сүүлээс эхлэн Монгол улсын экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээл дээрх үнэ өсч байна. Тодруулбал, нийлүүлэлт хумигдах, эрэлт өндөр хэвээр хадгалагдах төлөвтэй байснаас үүдэн зэсийн үнэ огцом өсчээ. Харин 2019 оноос төмрийн хүдэр, хүрэн нүүрсний үнэ буурч худалдааны нөхцөлийг муутгах нөлөө үзүүлэхээр байна.

¹ Боловсруулах, барилга, худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар

Урсгал дансны алдагдал тэлсэн ч санхүүгийн дансны ашиг илүү ихээр нэмэгдсэнээр нийт төлбөрийн тэнцэл сайжрахаар байгааг дурдав. Урсгал дансны хувьд түүхий эдийн үнийн төсөөлөл сайжирч, экспортын орлого нэмэгдэхээр байна. Гэвч гадаад зээл, бондын хүүгийн төлбөр болон орлогын дахин хөрөнгө оруулалтын (ОДХО) хэмжээ тус тус өсч байгаа нь урсгал тэнцлийн алдагдлыг тэлж байна. Санхүүгийн дансны хувьд гадаад зээл, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), худалдааны зээл өсөх нь тус дансны ашгийг нэмэгдүүлэхээр байна.

МБЗ-ийн гишүүдэд Монгол улсын нэгдсэн төсвийн орлого, төсвийн алдагдлын ойрын төлөвийг танилцууллаа. Төсвийн алдагдлыг бууруулах, өрийн тогтвортой байдлыг хангах зорилттой нийцтэйгээр ирэх онд төсвийн бодлого чангарах хүлээлттэй байна.

Мөнгөний нийлүүлэлт, зээлийн өсөлт нэмэгдэж байна. Гадаад валютын нөөц өсч, банкуудаас иргэдэд олгож буй хэрэглээний зориулалттай зээл хурдацтай нэмэгдэж байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голчлон тодорхойлж байна. Харин эдийн засгийн идэвхжлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зориулалттай бизнесийн зээл төдийлөн өсөхгүй байна.

МБГ-ын зүгээс төсөөлөл боловсруулахад учирч буй дараах тодорхой бус байдлыг онцлов. Инфляцийн төсөөллийн хувьд нийлүүлэлтийн шалтгаантай инфляци бий болох, Тодруулбал цаг агаарын нөхцөл байдлаас үүдэн махны үнэ төсөөллөөс илүү өсөх эрсдэлтэй. Мөн дотоод эдийн засгийн хувьд банк, санхүүгийн сектор, зээлийн төлөв цаашид хэрхэн өөрчлөгдөх нь тодорхой бус хэвээр байгаа бол гадаад эдийн засгийн хувьд геополитикийн асуудлууд болон Трампын худалдааны бодлогын эрдэс бүтээгдэхүүний үнэд үзүүлэх нөлөө зэрэг нь тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байгааг танилцууллаа.

Суурь төсөөллөөр 2018 онд инфляцийн түвшин зорилтот түвшнээс доогуур буюу 6.9 хувь, эдийн засгийн өсөлт 5.7 хувь байхаар байна. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэхээр байгаа хэдий ч нэг удаагийн шинжтэй болон зарим нийлүүлэлтийн шалтгаантай инфляци буурч, цаашид инфляци зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байгааг онцлов.

МБГ макро эдийн засгийн суурь төсөөллөөс гадна ЗБН-ийн журам өөрчлөгдөж байгаатай холбогдуулан ЗБН-ийн хувь хэмжээг төгрөгөөр татсан эх үүсвэрийн хувьд 1.5 нэгж хувиар бууруулах, гадаад валютын хувьд 12%-д хэвээр хадгалах (хувилбар 1), нүүрс, төмрийн хүдрийн дэлхийн зах зээл дээрх үнэ суурь төсөөллөөс буурах (хувилбар 2), бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 10 хувьд хүргэх (хувилбар 3) альтернатив хувилбаруудыг танилцууллаа.

Бодлогын хүүний тухайд МБГ-ын зүгээс бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 10 хувьд хүргэх саналыг дэвшүүлэв. МБЗ-ийн хурлаар гишүүд МБГ-ын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөв.

МБЗ-ийн гишүүдээс мөнгөний нийлүүлэлт төсөөллийн хугацаанд нэмэгдэх эрсдэлтэй байгааг дурдсан. Түүнчлэн, Засгийн газар 2019 онд иргэдийн цалинг нэмэгдүүлэх зорилт тавиад байгаа тул цалингийн суурь өсч, хэрэглээний зээлийг илүү нэмэгдүүлэх эрсдэлтэйг онцлов.

МБЗ-ийн дийлэнх гишүүд эдийн засгийн суурь үзүүлэлтүүд харьцангуй сайжирсан, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ харьцангуй өндөр байгаа болон хувийн сектор

эдийн засгийг эерэгээр харж эхэлж байна гэдгийг дурдсан бөгөөд бодлогын хүүг нэг нэгжээр бууруулах саналыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Мөн нэг гишүүний хувьд бодлогын хүүг 1 нэгжээс илүү өндрөөр бууруулж нэг оронтой тоонд оруулах саналыг гаргав. Нөгөө талаас зарим гишүүд бодлогын хүүг буулгах нь цаг үеэ олсон эсэхэд эргэлзэж байгаагаа илэрхийлсэн. Эдийн засгийн төлөв тоо мэдээнээс харьцангуй сайн харагдаж байгаа хэдий ч бизнесийн орчин бодит байдал дээр төдийлөн сайжраагүй хэвээр байна. Мөн Төв банкны тухай хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор 2018 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн мөнгөний бодлогын хороо УИХ-аас томилогдон ажиллахаар болсон. Энэ хүрээнд бодлогын хүүг дараагийн мөнгөний бодлогын зөвлөлийн хурлуудаар дахин буулгаж, мөнгөний бодлогын төлөвийг хэт сулруулах нөхцөл үүсэх эрсдэлтэйг онцолсон.

Эцэст нь манай улсын уул уурхайн салбарт хэрэгжиж буй томоохон төслүүд харьцангуй урт хугацаатай буюу 10-30 жилийн хугацаатайгаар хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр төслүүдийн бүтээн байгуулалт одоо явагдаж байгаа учир эргэлтийн хөрөнгөтэй холбоотой хүүгийн зардлыг бууруулах, эдийн засгийг идэвхжлийг дэмжих зорилгоор хүүг бууруулах нь зүйтэй гэж үзсэн.

Ийнхүү бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулж 10.0 хувьд хүргэх саналыг МБЗ-ийн гишүүд 100% дэмжив.

Хурлын дараагийн хэсэгт ЗБН-ийн журмын өөрчлөлттэй холбогдуулан хувь хэмжээг өөрчлөх бодлогын саналыг МБГ-ын зүгээс танилцууллаа. ЗБН тооцох журмыг олон улсын туршлагад нийцүүлэх, хөрөнгийн дотогшлох урсгал огцом нэмэгдэх үед макро зохистой бодлогын зорилгоор ашиглахад хялбар болгох, ЗБН ногдуулах эх үүсвэрийг тооцох данс, тооцоотой холбоотой зөрчил, хүндрэлийг бууруулах зорилгоор өөрчлөлт оруулсан байна.

Өмнөх зохицуулалтаар ЗБН тооцох эх үүсвэрийг 169 дансны нийлбэрээр тодорхойлдог байсныг 4 үндсэн том данс болон чөлөөлөгдсөн эх үүсвэрийн зөрүүгээр тодорхойлсноор ЗБН-ийн тооцоонд хамрагдахгүй үлддэг эх үүсвэрүүдийг хамруулсан. Мөн эх үүсвэрийн төрөл, хугацаанаас хамааруулан ЗБН-ийг ялгаатай тогтоох зохицуулалтыг нэмж, журамд тодорхойлогдоогүй зарим нэр томъёог тодорхойлон, ЗБН-ийн хангалт, ЗБН-ийн торгууль, ЗБН-ийн урамшуулалтай холбоотой зарим нэг заалтыг сайжруулсан байна.

Журам өөрчлөгдөж суурь тэлснээр банкуудын төгрөгийн ЗБН-ийн хэмжээ 147 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ (төгрөгийн эх үүсвэрийн ЗБН-ийн хувийг 12%-д хэвээр хадгалахад). Хэрэв төгрөгийн эх үүсвэрийн ЗБН-ийн хувийг 12%-иас 10.5% болгож бууруулвал төгрөгийн ЗБН-ийн хэмжээ 201 тэрбум төгрөгөөр буурах бөгөөд энэхүү хоёр өөрчлөлтийн нийлбэр нөлөөгөөр банкуудын төгрөгийн нөөц 54 тэрбум төгрөгөөр суларч байна. Харин журам өөрчлөгдөж суурь тэлснээр гадаад валютын ЗБН-ийн хэмжээ 206 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр (гадаад валютын ЗБН-ийн хувийг 12%-д хэвээр хадгалахад) байгааг танилцуулав.

Иймд МБГ-ын зүгээс журмын өөрчлөлтөөр ЗБН тооцох пассивын хэмжээ нэмэгдэж байгаагаар холбогдуулан банкуудын пассивын долларжилтыг бууруулах сэдлийг дэмжих зорилгоор ЗБН-ийн хувь хэмжээг төгрөгийн эх үүсвэрийн хувьд бууруулж 10.5%-д хүргэх, гадаад валютын эх үүсвэрийн хувьд 12%-д хэвээр хадгалах саналыг дэвшүүлэв. МБЗ-ийн хурлаар гишүүд МБГ-ын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөв.

МБЗ-ийн зарим гишүүдийн хувьд ЗБН-ийн журмыг өөрчилж, төгрөгийн ЗБН-ийн хувийг бууруулснаар бодит эдийн засагт гарах үр дүн харьцангуй бага байж болохыг дурдсан. Мөн ЗБН дээр гарж байгаа өөрчлөлтийг сайн сурталчилж, олон нийтэд зөв зүйтэйгээр таниулах хэрэгтэйг онцлов.

2018 оны 2 дугаар сарын тоо мэдээгээр гадаад валютын нээлттэй позицын зөрүү нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэхүү хандлага удаан хадгалагдвал банкны салбарын ханшийн хэлбэлзэлд өртөмтгий байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Иймд ЗБН-ийн хувьд гаргаж байгаа шийдвэр нь мөнгөний бодлого гэхээс илүү макро зохистой бодлогын хүрээнд гаргаж байгаа шийдвэр бөгөөд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс энэхүү арга хэмжээг авах нь зохистой гэж үзсэн.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1.5 нэгж хувиар бууруулж 10.5 хувьд хүргэх, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 12 хувьд хэвээр хадгалах саналыг 100% дэмжлээ.

Хурлын сүүлийн хэсэгт гишүүд “Монгол Улсад макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлэх стратеги”-ийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүллээ. МБЗ-өөс “Макро зохистой зохистой бодлогын стратеги”-ийг баталж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахыг холбогдох ажлын хэсэгт үүрэг болгов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2018 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувь болгох, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5 хувиар, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 12 хувиар тогтоох шийдвэр гаргасан. Бодлогын хүүний шийдвэрийг 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн, ЗБН-ийн хувь хэмжээний шийдвэрийг 2018 оны 5 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.